

**Нислэгийн цаг уурын төвийн
2019 оны 07 дугаар сард хийсэн ажлын тайлан**

2019.08.05

Зорилт:

Нислэгт цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх, нислэгийн зөрчил саатлын тоог бууруулах, албан хаагчдын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилт тавин ажилласан. Төвийн 2019 оны 7 дугаар сарын ажлын гүйцэтгэл 98.1 хувьтай байна.

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 07 дугаар сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ 223, урт хугацааны урьдчилсан мэдээ 128, районы урьдчилсан мэдээ 224, угталтын урьдчилсан мэдээ 172, өндрийн салхины урьдчилсан мэдээ 246, аэродромын урьдчилсан мэдээ 62, SIGMET 74, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 223, Тосонцэнгэл нисэх буудал орчмын TAF 65, Ханбумбат нисэх буудал орчмын TAF 162, Овоот нисэх буудал орчмын TAF 19, бусад нисэх буудал орчмын урьдчилсан мэдээ 61 удаа тус тус гаргаж, олон улсын 1257, орон нутгийн 911, онцгой ба тусгай үүргийн 18 нислэгийг 502 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын төрөл бүрийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Хэрэглэгчдийн хүсэлтээр цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахимаар өгч байна. Төв орон нутгийн 1451 бодит мэдээ, 2399 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 7 дугаар сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх систем /WAFS/-ийн бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 2.09%-иар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 1.76%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын байдлаас шалтгаалсан нислэгийн саатлын судалгаа: 7 дугаар сард нийт 43 саатал гарсан байна. Үүнд: таарсан 25, таараагүй урьдчилсан мэдээ 18.

Нислэгийн саатлыг үзэгдэл элементээр нь үзүүлвэл: Баруун хойдын салхитайгаас 11 нислэгийн гарсан бөгөөд урьдчилсан мэдээ таарсан 6, таараагүй 5, Зүүн өмнөдийн салхитайгаас 31 нислэг саатсанаас таарсан 18 таараагүй 13.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын бодит ажиглалтын мэдээ-1452, Уур амьсгалын ажиглалт-248, харьцуулсан ажиглалт-23, аюул-1, агаар-1, сарын дундаж мэдээ-4 удаа зохиосон.

Орон нутагт:

Олон улс болон орон нутгийн агаарын шугамд нислэг үйлдсэн үндсэн буудлын 832, бэлтгэл буудлын 1172 нислэгт, нислэгийн чиглэлийн урьдчилсан /НИ-5/ мэдээ 389, угталтын урьдчилсан мэдээ 27, буудал орчмын бодит мэдээ 4770, буудал орчмын урьдчилсан мэдээ 1622, районы урьдчилсан мэдээ 504, аэродромын урьдчилсан мэдээ 336, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 948, нам өндрийн нислэгийн замын дагуух аюултай үзэгдлийн мэдээ 3, зурвасын гадаргын байдлын мэдээг 53 дамжуулж үйлчилсэн.

Орон нутагт цаг агаараас шалтгаалсан 12 нислэгийн саатал гарсан бөгөөд районы цаг агаараас шалтгаалж 4, замын цаг агаараас 5, Ханбумбат нисэх буудалд хүлээх нислэг хийсэн 1, Өлгий нисэх буудалд чиглэл өөрчилсөн 2 нислэг саатсан байна.

Бусад ажлын талаар:

- 7 сарын 5-нд “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын менежментийг эхлүүлэх ёслолын арга хэмжээ”-ний үеэр үйлдэгдсэн нислэгт цаг уурын мэдээгээр үйлчлэх түр журам боловсруулан батлуулж, урьдчилсан болон бодит мэдээний үйлчилгээ үзүүлсэн. Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож төвийн үйл ажиллагааг сурталчилсан.
- 7 сарын 11-15-ны Үндэсний баяр наадмын өдрүүдээр ажиллах хариуцлагатай эргүүл жижүүрийн хуваарь гарган батлуулж, ажилласан.
- 7 сарын 08-13-ны өдрүүдэд “Торгоны зам” авто уралдааныг дагах нислэгүүдийн өмнөх хуралд оролцож, маршрутын дагуух цаг агаарын урьдчилсан төлвийг танилцуулж, хяналт тавьж хариуцлагатай эргүүлээр ажилласан.
- ЦУОШГ-ын даргын 7 сарын 22-ны өдрийн А/204 тоот тушаалаар “Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам” II дугаар дэвтэр шинэчлэн батлагдсан.
- 7 дугаар сарын 10-нд МИАТ ТӨХК-ийн “Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд”, хамтран ажиллах гэрээний дагуу Нислэгийн цаг уурын төвд аудит шалгалтын дүгнэлт ирсэн.
- 7 сарын 25-нд 2016-2019 оны хугацаанд НЦУТ-д хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын товч тайлан, зураг тайлбарыг FTP Туулцэцэг хавтсанд байршуулсан.

Сургалт дадлага, хурал, семинар:

Нэр	Албан тушаал	Ямар чиглэлээр сурсан	Хугацаа
Б.Болормаа	МҮХ-ийн дарга	Агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй ажиллагааны менежментийн тогтолцоо сэдэвт семинар	2019.07.02-2019.07.03
Л.Одгариг, Б.Тэмүүлэн	Ахлах синоптик инженер	Азийн бүсийн нисэхийн цаг уурын аюултай үзэгдэл, хамтын ажиллагаа сургалт, семинар, Цаг уурын тоон загварчлал ба синоптикийн сургалтуудад ахлах синоптик инженерүүд хамрагдагсан. БНХАУ-ын Бээжин хотноо	2019.06.30—2019.07.05
Б.Сүхбаатар	Ерөнхий технологич инженер	Цаг уурын тоон загварчлал ба синоптикийн сургалтад БНЭУ-ын Ахмедабад хотноо	2019.07.01-2019.07.12

Орон нутгийн УЦУОШТ-үүд болон нисэх буудлуудаас

Нэрс	Албан тушаал	Аймаг	Хугацаа
Х.Келгенбайн	Техникч	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	2019.06.17-2019.07.05
Э.Оюунтунгалаг	Техникч	Ховд аймгийн УЦУОШТ	2019.07.29-нөөс

Дүгнэлт:

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 7 дугаар сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.